

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/177/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Аудитор: О.Энхтөр

Утас: 95343496

Цахим хаяг: enkhturo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2026/177/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 02. 25 № 115

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж урсгал засварын зардлын төсвөөс 8,725.0 мянган төгрөгийн тавилга бэлтгэсэн, гэрэл цахилгааны зардлаас 1,100.0 мянган төгрөгийг чонын ав зохион байгуулахад зарцуулсан,
- Тайлант онд 19,909.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй,
- Тус байгууллагад жолоочийн албан үүргийг гүйцэтгэдэг ажилтнаас 8,725.0 мянган төгрөгийн сандал, ширээ худалдан авсан,
- Тайланд онд 4 албан хаагчид 9,650.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгосон боловч 2,830.0 мянган төгрөгийг дутуу суутгасан,

822511000348

- Төрийн аудитын байгууллагаас өгсөн 2022 оны 03/93, 05/93, 2023 оны 03/86, 06/86, 07/86, 10/86 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, заасан хугацаанд биелэлтийг ирүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.11, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаал, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагаас тайлант онд сонгуулийн үр дүнгээр ажлаасаа чөлөөлөгдсөн сумын Засаг даргад 56,848.5 мянган төгрөгийн тэтгэмж олгож авлагаар бүртгэсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 33,993.0 мянган төгрөгийн, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон 432,171.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна.

Аудитын гол асуудал

Өмнөх оны өглөгийг барагдуулахаар төсвөөс шийдвэрлүүлээгүй, төрийн сангаас зардал хязгаарласантай холбоотойгоор 12,592.3 мянган төгрөгийн өртэй гарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 8 зорилтын хүрээнд 211 арга хэмжээ хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан, гүйцэтгэлээр 94.6 хувиар дүгнүүлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г. ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	АВЛАГА	62,450,366.76	60,919,237.75
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	383,508.20	383,508.20
335	Бусад авлага	62,066,858.56	60,535,729.55
33510	Байгууллагаас авах авлага	13,440,688.56	3,687,221.55
33520	Хувь хүмүүсээс авах авлага	48,626,170.00	56,848,508.00
35	БАРАА МАТЕРИАЛ	87,442,093.20	87,442,093.20
354	Хангамжийн материал	12,532,093.20	12,532,093.20
35410	Бичиг хэргийн материал	149,775.00	149,775.00
35420	Аж ахуйн материал	12,382,318.20	12,382,318.20
35600	Мал амьтад	74,910,000.00	74,910,000.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	149,892,459.96	148,361,330.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,021,532,410.87	5,250,116,276.36
392	Биет хөрөнгө	3,474,885,810.87	3,703,469,676.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,480,187,461.85	2,780,187,461.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(297,814,940.51)	(390,753,568.51)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	249,838,172.00	249,838,172.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(97,061,296.87)	(125,808,796.75)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	432,517,745.00	560,172,206.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(336,066,960.66)	(372,987,680.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	194,130,300.97	225,915,300.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	(91,134,733.61)	(107,670,578.09)
39209	Зам, гүүрийн байгууламж	213,000,000.00	213,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(6,508,333.26)	(13,016,666.52)
39214	Бусад үндсэн хөрөнгө	944,449,796.63	953,449,796.63
39215	Хуримтлагдсан элэгдэл	(213,880,634.67)	(272,384,205.39)
39217	Ном	3,229,234.00	3,528,234.00
393	Биет бус хөрөнгө	1,546,646,600.00	1,546,646,600.00
39301	Програм хангамж	1,740,000.00	1,740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,740,000.00)	(1,740,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,546,646,600.00	1,546,646,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,021,532,410.87	5,250,116,276.36
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,171,424,870.83	5,398,477,607.31
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	75,585,866.71	12,592,341.60
413	Өглөг	75,585,866.71	12,592,341.60
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	46,450,078.51	7,708,688.40
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,392,623.20	4,883,653.20
4136	Бусад өглөг	21,743,165.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	21,743,165.00	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	75,585,866.71	12,592,341.60
51	Засгийн газрын хувь оролцоо	5,095,839,004.12	5,385,885,265.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	626,748,340.32	626,748,340.32
511001	Засгийн газрын оруулсан капитал загийн газрын сан	626,748,340.32	626,748,340.32
512	Хуримтлагдсан үр дүн	3,939,685,370.93	4,229,731,632.52
51210	Өмнөх үеийн үр дүн	3,758,520,515.23	3,949,797,535.93
51220	Тайлант үеийн үр дүн	181,164,855.70	279,934,096.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	529,405,292.87	529,405,292.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,095,839,004.12	5,385,885,265.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,171,424,870.83	5,398,477,607.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	919,010,733.00	1,100,923,722.95
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	163,664,033.00	35,328,423.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	163,664,033.00	35,328,423.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	755,346,700.00	1,065,595,299.95
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	755,346,700.00	1,065,595,299.95
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	456,864,426.66	434,745,461.93
120	Нийтлэг татварын бус орлого	456,864,426.66	434,745,461.93
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	456,864,426.66	434,745,461.93
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,375,875,159.66	1,535,669,184.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,063,203,259.72	1,255,735,088.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,015,893,978.75	1,146,515,374.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	575,733,730.65	682,948,475.77
210101	Үндсэн цалин	336,837,216.87	468,907,166.55
210102	Нэмэгдэл	227,654,801.50	192,557,506.53
210104	Урамшуулал	11,241,712.28	21,483,802.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,551,071.46	89,359,395.99
210201	Тэтгэврийн даатгал	58,263,674.08	58,615,395.99
210202	Тэтгэмжийн даатгал	4,821,299.42	7,686,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,411,199.21	3,843,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,411,199.35	3,843,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,643,699.40	15,372,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,897,960.80	46,131,721.18
210301	Гэрэл, цахилгаан	6,630,716.00	10,862,721.18
210302	Түлш, халаалт	39,267,244.80	35,269,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,208,981.85	35,625,820.00
210401	Бичиг хэрэг	5,722,400.00	3,046,500.00
210402	Тээвэр, шатахуун	39,622,448.85	29,257,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,044,033.00	1,796,210.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	820,100.00	1,525,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,002,400.00	14,429,900.00
210604	Урсгал засвар	3,002,400.00	14,429,900.00
2107	Томилолт, зочны зардал	4,504,217.00	5,730,000.00
210702	Дотоод албан томилолт	4,504,217.00	5,730,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,049,000.00	21,577,765.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,146,250.00	21,024,515.00
210803	Даатгалын үйлчилгээ	462,750.00	113,250.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	222,946,616.99	250,712,296.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,259,500.00	9,732,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	269,000.00	825,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	208,418,116.99	240,154,596.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,309,280.97	109,219,713.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,650,449.00	19,697,850.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,614,449.00	18,947,850.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,036,000.00	750,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,658,831.97	89,521,863.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,658,831.97	89,521,863.91
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	98,146,335.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	98,146,335.00	-
223001	Бусад хөрөнгө	98,146,335.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,161,349,594.72	1,255,735,088.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	214,525,564.94	279,934,096.59

**Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	33,360,709.24	
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	33,360,709.24	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(33,360,709.24)	-
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	181,164,855.70	279,934,096.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	936,010,733.00	1,110,923,722.95
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	180,664,033.00	45,328,423.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	180,664,033.00	45,328,423.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	755,346,700.00	1,065,595,299.95
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	755,346,700.00	1,065,595,299.95
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	936,010,733.00	1,110,923,722.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	830,465,398.00	1,110,923,722.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	774,601,105.40	1,001,457,476.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	546,590,526.65	711,751,495.37
210101	Үндсэн цалин	307,694,012.87	497,710,186.15
210102	Нэмэгдэл	227,654,801.50	192,557,506.53
210104	Урамшуулал	11,241,712.28	21,483,802.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,271,196.95	107,520,104.50
210201	Тэтгэврийн даатгал	40,983,799.57	76,776,104.50
210202	Тэтгэмжийн даатгал	4,821,299.42	7,686,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,411,199.21	3,843,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,411,199.35	3,843,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,643,699.40	15,372,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,766,960.80	50,262,721.18
210301	Гэрэл, цахилгаан	6,630,716.00	10,862,721.18
210302	Түлш, халаалт	35,136,244.80	39,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,456,333.00	38,433,790.00
210401	Бичиг хэрэг	5,722,400.00	2,923,500.00
210402	Тээвэр, шатахуун	35,869,800.00	31,889,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,044,033.00	1,796,210.00
210404	Ном, хэвлэл	0.00	299,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	820,100.00	1,525,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,964,496.00	47,563,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,962,096.00	22,409,000.00
210604	Урсгал засвар	3,002,400.00	25,154,900.00
2107	Томилолт, зочны зардал	4,504,217.00	5,730,000.00
210702	Дотоод албан томилолт	4,504,217.00	5,730,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,518,875.00	29,637,765.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,616,125.00	29,084,515.00
210803	Даатгалын үйлчилгээ	462,750.00	113,250.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,528,500.00	10,557,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,259,500.00	9,932,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	269,000.00	625,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,864,292.60	109,466,246.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,650,449.00	19,697,850.00



**Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,614,449.00	18,947,850.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,036,000.00	750,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,213,843.60	89,768,396.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,658,831.97	89,521,863.91
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,555,011.63	246,532.99
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	<u>830,465,398.00</u>	<u>1,110,923,722.95</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	105,545,335.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	105,545,335.00	0.00
223001	Бусад хөрөнгө	105,545,335.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	105,545,335.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-105,545,335.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	3,758,520,515.23	4,914,674,148.42
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	3,758,520,515.23	4,914,674,148.42
C09	Тайлант үеийн үр дүн	-	-	181,164,855.70	181,164,855.70
C10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	3,939,685,370.93	5,095,839,004.12
C11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	3,939,685,370.93	5,095,839,004.12
C12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	10,112,165.00	10,112,165.00
C13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	3,949,797,535.93	5,105,951,169.12
C19	Тайлант үеийн үр дүн	-	-	279,934,096.59	279,934,096.59
C20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	4,229,731,632.52	5,385,885,265.71


2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,062,891,400.00	976,073,436.04	86,817,963.96	91.8



**Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

УРСГАЛ ЗАРДАЛ	1,062,891,400.00	976,073,436.04	86,817,963.96	91.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,042,410,400.00	956,375,586.04	86,034,813.96	91.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	749,114,800.00	711,751,495.37	37,363,304.63	95.0
Үндсэн цалин	676,000,000.00	497,710,186.15	178,289,813.85	73.6
Нэмэгдэл	73,114,800.00	192,557,506.53	(119,442,706.53)	263.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,276,600.00	107,520,104.50	30,756,495.50	77.8
Тэтгэврийн даатгал	107,532,600.00	76,776,104.50	30,756,495.50	71.4
Тэтгэмжийн даатгал	7,686,000.00	7,686,000.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	3,843,000.00	3,843,000.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	3,843,000.00	3,843,000.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	15,372,000.00	15,372,000.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,660,000.00	43,304,726.17	355,273.83	99.2
Гэрэл, цахилгаан	4,000,000.00	3,904,726.17	95,273.83	97.6
Түлш, халаалт	39,400,000.00	39,400,000.00	-	100.0
Цэвэр, бохир ус	260,000.00	-	260,000.00	-
Хангамж, бараа материалын зардал	35,579,000.00	29,394,410.00	6,184,590.00	82.6
Бичиг хэрэг	3,600,000.00	2,923,500.00	676,500.00	81.2
Тээвэр, шатахуун	27,479,000.00	23,000,000.00	4,479,000.00	83.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,646,210.00	153,790.00	91.5
Ном, хэвлэл	300,000.00	299,000.00	1,000.00	99.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400,000.00	1,525,700.00	874,300.00	63.6
Эд хогшил, урсгал засварын зардал	55,620,000.00	47,563,900.00	8,056,100.00	85.5
Багаж, техник, хэрэгсэл	29,000,000.00	22,409,000.00	6,591,000.00	77.3
Урсгал засвар	26,620,000.00	25,154,900.00	1,465,100.00	94.5
Томилолт, зочны зардал	6,000,000.00	5,730,000.00	270,000.00	95.5
Дотоод албан томилолт	6,000,000.00	5,730,000.00	270,000.00	95.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,810,000.00	553,250.00	2,256,750.00	19.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	620,000.00	-	620,000.00	-
Даатгалын үйлчилгээ	350,000.00	113,250.00	236,750.00	32.4
Тээврийн хэрэгслийн татвар	240,000.00	-	240,000.00	-
Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	-	100,000.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	440,000.00	60,000.00	88.0
Газрын төлбөр	1,000,000.00	-	1,000,000.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	11,350,000.00	10,557,700.00	792,300.00	93.0
Бараа үйлчилгээний бусад зардал	9,800,000.00	9,932,500.00	(132,500.00)	101.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,550,000.00	625,200.00	924,800.00	40.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,481,000.00	19,697,850.00	783,150.00	96.2
Бусад урсгал шилжүүлэг	20,481,000.00	19,697,850.00	783,150.00	96.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,981,000.00	18,947,850.00	33,150.00	99.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	750,000.00	750,000.00	50.0



ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,062,891,400.00	976,073,436.04	86,817,963.96	91.8
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,062,891,400.00	976,073,436.04	86,817,963.96	91.8
Орон нутгийн төсвөөс	1,062,891,400.00	976,073,436.04	86,817,963.96	91.8

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,328,423.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,328,423.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,081,890.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,957,995.01
210301	Гэрэл, цахилгаан	6,957,995.01
2104	Хангамж, бараа материалын зардал	9,039,380.00
210402	Тээвэр, шатахуун	8,889,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,084,515.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,084,515.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	246,532.99
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	246,532.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	246,532.99
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,328,423.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,328,423.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,328,423.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгээгүй.

Залруулагдаагүй нийт 23,839.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Нийт 23,839.0 мянган төгрөгийн 5 зөрчил¹ илэрсэнд 1 төлбөрийн акт, 2 зөвлөмж, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

1. Тайланд онд 4 албан хаагчид 9,650.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгосон боловч 2,830.0 мянган төгрөгийг дутуу суутгасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу суутгасан 2,830.0 мянган төгрөгийг ажилчдаас суутган авч Төрийн сан дахь Га.Аудитын орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт хүргүүлсэн.

3.2 Албан шаардлага

1. Тайлант онд 19,909.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төрийн аудитын байгууллагаас өгсөн 2022 оны 03/93, 05/93, 2023 оны 03/86, 06/86, 07/86, 10/86 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, заасан хугацаанд биелэлтийг ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана", гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Т.Сүхбаатарт хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Төсвийн зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт: Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж гэрэл цахилгааны зардлаас 1,100.0 мянган төгрөгийг чонын ав зохион байгуулахад, урсгал засварын зардлын төсвөөс 8,725.0 мянган төгрөгийн тавилга бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", "Ангилал шинэчлэн батлах тухай" Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зориулалтын дагуу зарцуулан, хууль тогтоомжоор хориглосон зардалд зарцуулахгүй байх.

Хоёр. Хууль тогтоомжтой холбоотой

Илрүүлэлт: Тус байгууллагад жолоочийн албан үүрэг гүйцэтгэдэг албан хаагчаас 8,725.0 мянган төгрөгийн сандал, ширээ худалдан авсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.11."ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал" гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг", 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно." заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хамаарал бүхий болон ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц этгээдээс худалдан авалт хийх, гэрээ хэлцэл байгуулах, тэдгээртэй адилтгах үйл ажиллагаа явуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4. Аудитаар залруулсан алдаа, илэрсэн зөрчлийн нэгтгэл

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	Тайланд онд 4 албан хаагчид 9,650.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгосон боловч 2,830.0 мянган төгрөгийг дутуу суутгасан байна.	1	2,830.0	1	2,830.0	-	-	-	-	-	-
	Төрийн аудитын байгууллагаас өгсөн 2022 оны 03/93, 05/93, 2023 оны 03/86, 06/86, 07/86, 10/86 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, заасан хугацаанд биелэлтийг ирүүлээгүй байна.	1	19,909.0	-	-	1	19,909.0	-	-	-	-
	Цехим дэлгүүрээс 19,909.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг худалдан аваагүй.										
Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газар	Тус байгууллага нь өөрийн хамаарал бүхий этгээд болох жолоочийн ажил эрхэлдэг ажилтнаас 8,725.0 мянган төгрөгийн сандал, ширээ худалдан авсан байна.	1	8,725.0	-	-	-	-	1	8,725.0	-	-
	Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж гэрэл цахилгааны зардлаас 1,100.0 мянган төгрөгийг чонын авд зориулсан галт зэвсэгийн сум, Урсгал засварын зардлаас 8,725.0 мянган төгрөгийн тавилга бэлтгэсэн байна.	1	1,100.0					1	1,100.0		
	Дүн	4	32,564.0	1	2,830.0	1	19,909.0	2	9,825.0	-	-



Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэржийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		

